

# Өмнөговь аймаг ба говийн бүсийн уул уурхай, ил тод байдлын нэгдсэн чуулга уулзалт



Уул уурхай,  
хүнд үйлдвэрийн яам



Өмнөговь аймгийн  
Засаг даргын  
тамгын газар



Монголын Олборлох  
үйлдвэрлэлийн ил тод  
байдлын санаачилга

## ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ

2022.06.23-24

Өмнөговь аймгийн Даланзадгад хот

### Дэмжигч байгууллагууд



- УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
- БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
- ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
- ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
- АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
- АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
- ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
- БООМТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
- ГАШУУН СУХАЙТ БООМТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗАР
- ШИВЭЭХҮРЭН БООМТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗАР
- ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
- ОУИТБС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ
- ОУИТБС-ЫН АЖЛЫН АЛБА
- ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛ
- ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦ
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОАЖГ
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУМДЫН ЗДТГ
- ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗДТГ
- ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
- ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ, ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗДТГ
- "МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦ"
- "НҮҮРС АССОЦИАЦ"
- "ТӨЛСӨН АВСНАА НИЙТЭЛ" ТББ
- "НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ" ТББ
- "ТРАНСПЭРЕНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ" ТББ
- "МОНГОЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ" ТББ
- "ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВ" ТББ
- "ИЛ ТОД БАЙДАЛ" ТББ

## Оролцогчид

- "ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
- "ТАВАН ТОЛГОЙ" ХК
- "ОЮУ ТОЛГОЙ" ХХК
- "ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК
- "МОНГОЛЫН АЛТ МАК" ХХК
- "ӨСӨХ ЗООС" ХХК
- "ХҮРЭН ТОЛГОЙ КОЭЛ МАЙНИНГ" ХХК
- "САУС ГОБИ СЭНДС" ХХК
- "ЖАВХЛАНТ ОРД" ХХК
- "ТЕРРА ЭНЕРЖИ" ХХК
- "ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ" ХХК
- "МӨНХ НОЁН СУВАРГА" ХХК
- "ХАНГАД ЭКСПЛОРЕШН" ХХК
- "ЗАНАДУ МАЙНЗ" ХХК
- "ЖИ ӨҮ ЭЙЧ" ХХК
- "ХЕРУГА ЭКСПЛОРЕЙШН" ХХК
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО
- "ТАВАНТОЛГОЙ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК
- "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ТӨХҮГ
- "ЗҮҮНБАЯН ТӨМӨР ЗАМ" ТӨХҮГ
- "ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК



Уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэр, түүнийг дагасан зам тээврийн нөлөөлөл ойр орчимд амьдарч байгаа иргэдийн эрүүл мэнд, амь нас цаашлаад үр удамшилд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд учирч буй заналхийлэл юм.

Мөн малчид, мал, ан амьтан уул уурхайгаас үүдэлтэй үйл ажиллагааны нөлөөлөлд маш их өртөж эрх нь зөрчигдөж байна.

Иймд говийн бүсийн иргэдийн зүгээс дараах саналыг УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар болон төрийн холбогдох байгууллагуудад хүргүүлж байна.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД

1. Говийн бүсэд хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл нэмж олгохыг хориглосон тухай зарлиг гаргаж өгнө үү;
2. Уул уурхайн бүс нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, ам нас, үр удам уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөж, ихэд хохирч байгааг анхааралдаа авч, сөрөг нөлөөллийг бууруулах талаар шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгоно уу;
3. Монгол Улсын Үндсэн Хуулийн 6.2 дахь заалтын “нийтийн” гэснийг “ард түмний” гэж өөрчилж өгнө үү;
4. Дээрх асуудлуудыг онцгой анхаарч дахин гаргахгүй байх талаар бодлогоор зохицуулахыг Засгийн газарт үүрэг болгож өгнө үү;
5. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийнхээ хэмжээнд говийн бүс нутагт гадаргын болон гүний усыг уул уурхай, үйлдвэрлэлд хэрэглэхэд хориг тавьж өгнө үү;

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД

1. Уул уурхайн үйл ажиллагаанд говийн гүний усыг ашиглахыг хориглосон заалтыг Усны тухай хуульд оруулах;
2. Эрдэс баялгийн төсөл хэрэгжүүлэхийн өмнө Хүний эрх, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийсний дараа тусгай зөвшөөрөл олгодог байх хуулийн заалтыг Ашигт малтмалын тухай хуульд оруулах;
3. Уул уурхайн нөлөөлөлд өртөж байгаа иргэдэд нийгэм, эдийн засаг болон эрүүл мэндийн нөхөн олговор олгохыг хуульд тусгаж өгөх;
4. Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2 дахь заалт болон НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1962 оны 1803 дугаар тогтоол зэргийг үндэслэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг Монголын ард иргэдэд хувьцаа хэлбэрээр эзэмшүүлэх, хуулийн нэмэлт өөрчлөлтийг хийх;
5. Уул уурхайн нөлөөлийн бүсчлэлийг нарийвчлан тогтоохоос өмнө хүний эрүүл мэнд, амь нас, үр удам, мал, ан амьтан, ус ургамалд гарах хохирлын хэмжээ, стратегийн болон хуримтлагдах нөлөөлийн үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагаас шаардах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас хохирол учруулахаар бол хохирлыг нөхөн төлүүлэх холбогдох аргачлал, зохицуулалтыг батлахыг Засгийн газарт үүрэг болгох;

## ГОВИЙН БҮСЭЭС СОНГОГДСОН УИХ-ЫН ГИШҮҮДЭД

1. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төсөлд олон нийтийн саналыг тусгах ажлыг зохион байгуулах;

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ

1. Уул уурхайн нөлөөллийн бүсчлэлээр бүс тус бүрийн хүний эрх, нийгмийн нөлөөллийн үнэлгээг нарийвчилан боловсруулж, нөлөөллийн эрчим, хор уршгийг тодорхой болгох;
2. Уул уурхай, түүний дагалдах зам, барилга гэх мэт дэд бүтцийн төслийн нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг олон улсын стандартын дагуу баталж, байгаль орчин нийгмийн нөлөөллийн цогц үнэлгээний тогтолцоог бий болгох;
3. Цаашид хайгуулын талбайн солбицол тогтоохоос өмнө бүс нутгийн нийгмийн нөлөөллийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар эерэг ба сөрөг нөлөөллийг тодорхойлон, шийдвэрлэх аргачлалын төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагаар зайлшгүй гаргуулж талбайн солбицлыг тогтоох;
4. “Өлзий - Цагаандэл уул” чиглэлд байнгын ажиллагаатай авто замын боомт байгуулах тухай Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолын 1 дэх хэсгийг хүчингүй болгож, нийтэд мэдээлэх;
5. 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Монгол Улсын Засгийн газар “Ундрах говь” компанитай 270 км авто зам барих концессийн гэрээг хүчингүй болгох;
6. Шороон замаар хүнд даацын тээвэр хийхийг хориглосон тухай Засгийн газрын 2018 оны тогтоолыг Авто замын тухай хуулийн заалт болгож оруулах;
7. Говийн бүсэд уул уурхайн салбарын бодлогын хэрэгжилтэд стратегийн үнэлгээ хийлгэх;
8. Уул уурхайн ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах болон түүнийг дагасан зам, тээврийн үйл ажиллагаа эрхлэх гэж буй ААН-үүдийн тухайн лицэнзийн талбайн нөлөөллийн бүсийн иргэд, мал, ан амтан, ургамал, усны нөлөөлөх байдлаа арилгаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, тухайн бүсэд ямарч хор нөлөөгүй болсон гэдэг баталгааг иргэд, ИНБ, орон нутгийн удирдлагуудаар хуулийн дагуу баталгаажуулж байж үйл ажиллагаа эрхэлдэг болохыг хуульчилж өгөх;

## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

1. Өмнөговь аймгийн Баяндалай, Хүрмэн, Ханхонгор, Номгон, Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд гэсэн 7 суманд шинээр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх шийдвэрийг албажуулан гаргах;
2. Хүний амь нас, эрүүл мэнд, ген удамшлын аюулгүй, бүрэн бүтэн байдлыг дээдэлж, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, эрх чөлөөг дээдлэх, тухайн орон нутгийн иргэд баялагийнхаа эзэн нь байж, хувь хүртэх, хувьцаа эзэмшдэг болох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

1. Замын маршрут тогтооход орон нутаг, иргэдийн саналыг тусгах механизмыг хууль эрх зүйн орчинд бий болгох;
2. Концессийн гэрээт замын хэрэгжилтэд нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хяналтыг бий болгох;

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД

1. Сэргээгдэх эрчим хүч /нар, салхины/ ашиглалтыг бодлогоор дэмжих ажлыг шинэ шатанд гаргах;
2. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд өрх бүрээс сард авч буй орлогын зарцуулалтыг ил тод тайлагнаж хэвших;

## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

1. “Тахилт хайрхан транс” компанитай байгуулсан концессийн гэрээг сайжруулж, шороон замын нүүрс тээврийг зогсоож, байгаль орчин, хүний эрхэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх түр ажлын хэсэг байгуулах;

## ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Тухайн уул уурхай, тээвэрлэлтийн тоос, дуу чимээ нь нөлөөллийн бүсэд буй иргэдийн эд эрхтэнд хэрхэн нөлөөлж ямар ямар өвчин үүсгэж байгааг жил жилээр нь шинжилж тогтоох нарийн мэргэжлийн эмч, эрдэмтдийн хамтарсан эрдэм шинжилгээний баг ажиллуулж, шаардлагатай төсөв хөрөнгийг хамтын ажиллагааны сангаас гаргах;
2. Эрдэм шинжилгээний багаас гарсан судалгааны дүнг төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн албан ёсоор баталгаажуулах. Мөн яг ийм лабораторыг мал, ан амьтан, ус ургамлын шинжилгээ хийх хүрээлэнд байгуулах;

***Өмнөговь аймаг ба говийн бүсийн уул уурхай, ил тод байдлын нэгдсэн чуулга уулзалтын зохион байгуулагчид***

